

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэнд-Очир	Дугаар	L170
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ	Оршин суугаа сум	Ерөө
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Ерөө сумын иргэн		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Минжийн дуган, Хэрхийн дуган	Сүм хийдийн дугаар	СЭЕР 030, СЭМН 003
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Минжийн дуган, Мандал сумын Хэрхийн дуган

Асуулт:-Та бидэнд Минжийн **дуганын** тухай ярьж өгнө үү?

Хариулт:-Минжийн дуган дээр үед барьсан, их олон жилийн түүхтэй юм билээ, их л эртний юм байна лээ.

Минжийн өөрийнх нь оршин суугчид голдуу хамниган буриадууд байсан байгаа юм. Тэр буриадууд Бүрэнжаргал овооны урд талд суурилуулж барьсан байгаа юм. **Хамниганууд** голдуу омог гэрээр амьдарч байсан учраас өглөө цуглаж дуган дээрээ ирж хурлаа **хурчихаад** тэгээд дараа нь үдээс хойшно шиг буга бариад гөрөөлөөд явж байсан гэж тэгж ярьдаг юм.

1930 оноос эхлээд засаг захиргааны хуваариар Минжийн айлуудыг нааш нь нүүлгэж татаж бөөгнөрүүлж ирснээс Минжийн нутаг **эзэнгүйрч** Минжийн дуганд цуглаж хурах зам байхгүй болсон юм. Дараа нь 1945 оны чөлөөлөх дайнаас хойш нутгийн засаг захиргаанаас голцуухан шиг партизанууд Цэрэндорж, Дамдин, Аюур, Дамба, **Одонлуvsан**, Бавуудорж, Цэндсүрэн гуай гэсэн 17 хүнийг томилж явуулж, тэд нарын зорилго бол

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Минжид орогнож байсан улаан Цэнд гэдэг оросыг барих зорилготой гэж байгаа юм. Тэрнийг барьж чадахгүй байсаар байгаад сүүлд нь 47 онд ахиж яваад төлөөлөгч Лувсандагваар толгойлуулсан 17 хүн очиж тэр Цэндийг барьж чадаагүйдээ өширхөөд дуганыг шатаасан байгаа юм.

Асуулт:-Уг нь лам нарыг нааш нь татаад дуган нь эзэнгүйдээд нураалгүй үлдээчихсэн байсан юмуу?

Хариулт:-Тийм. Тэгээд тэр орогнож байсан орон нь болохоос биш тэрэнд юм байгаагүй.

Асуулт:-Бурхан тахил бүгдийг байхгүй болгочихсон?

Хариулт:-Бурхан тахилыг авахыг нь аваад хаяхыг нь хаяад тэр нутгийнх нь авах нь аваад **тэгээд** орхичихсон байсан юм байна лээ. **Тэгээд тэр** дуганыг шатааснаас хойш тэнд дахиж очих **юу байхав**, дуганых нь буурь байж л байсан одоо намаг, чулуу нь доошоо шигдээд мэдэгдэхээ байчихсан. Бүрэнжаргалан овооны урд талд байшин нь би очиж үзэж байсан юм.

Асуулт:-Бурхан тахилыг нь яасан юм бол?

Хариулт:-Бурхан тахилыг нь хүн амьтан аваад, сүүлд нь ганц нэг юм байсныг нь аваад дууссан юм байна лээ.

Сүүлд нэг бурхан нь буурал хайрханы өвөрт овоон дээр нэг бурхан байхыг нь үзсэн. Тэр одоо байхгүй болоо биз дээ.

Асуулт:-Ямархуу бурхан шүтээнтэй байсан юм бол гол шүтээн нь.

Хариулт:-Гол шүтээнийг нь би мэдэхгүй юм. Би Буурал хайрханы өвөрт байсан овоон дээр байсан **бурханыг үзэхэд** 50 см өндөр ямар бурхан гэдэг юм ногоон дарь эх нь юмуу, цагаан дарь эх нь юмуу эмэгтэй бурхан байсан юм. Тэр л гол шүтээн нь байсан юм болов уу гэж санадаг юм.

Асуулт:-Минжийн дуганы лам нар тэр хавийнхаа ямар уул овоог тахидаг байсан юм бол.

Хариулт:-Буурал **богд очироо тахидаг** байсан, Бүрэнжаргал овоогоо тахиж байсан байгаа юм. Буурал богд **очир**ыг та нар хараа биз дээ, энэ дээрээ хоёр **шовхтой** уулыг чинь **Очирбогд** гэдэг юм. Тэр дээд талын өндөр модтой, хадтай уулыг нь Буурал.

Асуулт:-Том **агуйтай** нэг уул байсан шүү дээ. Бид нарыг ирэхэд.

Хариулт:-Тэр агуйг чинь юу гэлээ. Сүүлийн үед Цэндийн агуй гэж яриад байгаа юм. Дээр үедээ Минжийн агуй гэж ярьж байсан юм.

Асуулт:-Овоогоо хэдэн сард тахидаг байсан юм бол?

Хариулт:-Цагаан сараар тахиж байсан байх, тэгээд хавар хүр бороо оруулах барих гээд бас нэг тахилга явуулж байсан байлгүй.

Асуулт:-Нутгийн хамниган буриадууд өөрсдөө?

Хариулт:-Өөрсдөө л тахиж байсан, тусгай лам нар байгаагүй. **Шивэрийн Баянтохойгийн** дуган ч гэсэн ялгаагүй тийм байсан байгаа юм шүү.

Асуулт:-Нутгийн ардууд нь хурал номоо хурчихдаг?

Хариулт:-Тийм. Хурал номоо **хурчихаад** буугаа үүрээд анд явдаг тийм байсан байгаа юм.

Асуулт:-**Ар ишлэхийн** дуган гэж байгаа шүү дээ, халуун рашааны тэнд байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тэр бол өндөр гэгээн Занабазар **Галданбошигтоос зугатааж** явж байхдаа халуун рашааны чинь тахиж барьж 3 бурхан. Эмэгтэй ямар бурхан гэдгийг мэдэхгүй. Эмэгтэй хүний дүрстэй **бурханууд** хадан дээр 3-ыг товойлгож сийлсэн. Тэгээд тэр рашааныг тахиж барьж аравнайлж барьж рашааныг нээж байсан гэж ярих юм билээ. **Тэрэн** дээр чинь сууж номоо уншиж байсан гэж ярьдаг юм байна лээ. Тэгээд цаашаагаа **Галданбошигтоос зугатаагаад** цаашаагаа Минж ороод Минжээсээ урагшаа эргэхдээ Естийн рашаанаар дамжиж явж байсан юм байна лээ. Тэгээд Ерөөгийн рашааныг бүр хувьсгалаас өмнө гэхэд байшин бариад тохижуулсан байгаа юм.

Асуулт:-Хурал ном хурж байсан уу? тэнд.

Хариулт:-Хурал ном өөрсдөө очиж хурж байсан, тэрнээс тусгай лам байхгүй.

Асуулт:-Хэд орчим хүмүүс байсан юм бол?

Хариулт:-Юу базаадаг юм бэ? Сайндаа л арав биз. Тэгээд Ерөөгийн рашааны дуганыг 1936 онд Ардын засгаас сэргээж дуган бариад, байшин бариад тохижуулсан. Тэгээд сая 88 он гэхэд тэрнийг чинь тохижуулаад дахиж дуганыг чинь сэргээж бариад байшингуудыг нь сэргээж барьсан нь одоо тэр шатчихаад байгаа чинь байхгүй юу.

Асуулт:-Биднийг тэнд очиход шатчихсан байна лээ, юу ч үлдээгүй.

Хариулт:-Тийм, юу ч байхгүй. 300 жилийнхээ түүхтэй юмыг **устгачихаад** байна шүү дээ. Тусгүй л юм болсон доо.